



ՄԵԾ ԵՐԽՈՒՄԻՆ ԶԵՏԱԳ ԴԱՐԴԱ ՏՏԱԶԵՅ-ՅԻՆ ՏԱԻԴՏԱԻ ԵՐԴԴՍՄԼՏԱՆ ԴՐՅՅՅՆԻԻ ԵՐԵԼՔԼՏ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, СОЁЛ СПОРТ, АЯЛАЛ ЖУУЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД,
УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны 11 сарын 25

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт		
		Зарцуулсан хөрөнгө	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
ДӨРӨВ. 1.1 Засаг дарга нь дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ				
1	4.2. Аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд багтагдсан соёл, урлаг, соёлын өв, биеийн тамир, спорт, аялал жуулчлал, залуучуудыг хөгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангана.	250,0	Гүйцэтгэлийн хувь	100%
2025 онд спорт, нийтийн биеийн тамирын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Спортын 22 холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулж, 89.6 сая төгрөгийн санхүүжилтыг олгосон байна. 2025 онд УАШТ-3, баруун бүсийн -2, аймаг, сумын 36 арга хэмжээг зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд 12 сарын байдлаар спортын 155 уралдаан тэмцээнд нийт 39341 гаруй, нийтийн биеийн тамирын 88 арга хэмжээнд 25384 иргэн нийт 68250 иргэн хамрагдсан байна. 2021-2025 онд Олон улсын хэмжээний "Их Алтай-2023", "Энхийн гүйлт", улсын хэмжээний "Нэг аймаг 100 км" явган алхалт, "Үндэсний цом-2022" хөл бөмбөгийн аварга, чөлөөт бөх, даамын улсын аварга шалгаруулах тэмцээн, Жүдо, байт харвааны баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээн "Хонхот бөмбөг" улсын аварга, "Оюутны спорт, урлагийн их наадам", "Хүүхдийн спортын 7,8-р их наадам", "Аваргуудын нэрэмжит үндэсний бөхийн барилдаан", "Нөхөрлөг" сурагчдын волейболын лиг зэрэг томоохон уралдаан, тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулж, дэмжиж ажиллаа. 2021-2024 онд Увс аймгийн баг, тамирчид тив, дэлхий болон улсын аварга шалгаруулах тэмцээнд 20 гаруй төрлөөр оролцож, 425 медаль хүртлээ. Амжилт гаргасан тамирчин, багш, дасгалжуулагч нарт 365,9 сая төгрөгийн дэмжлэг, урамшуулал олголоо. Илүүдэл жингүй эртэч Монгол, "Эрүүл мэндийн цахим гүйлт", "Дасгал хөдөлгөөнөөр хичээллэцгээе", "Цахим гимнастрада", "Увсын цэнхэр хязгаар-Хяргас нуур" зэрэг				

					томоохон аян, арга хэмжээг зохион байгуулж, 40-50 мянган иргэнийг спорт, нийтийн биеийн тамирын арга хэмжээнд жил бүр хамруулан ажилласан. Үр дүн: Биеийн тамир, спортын арга хэмжээнд жилд 40-50 мянган иргэн хамрагдаж, суурь түвшнээс 4-5 дахин өснөө. Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагчдаас А, В, С үнэлгээтэй иргэдийн тоо 2021 онд 33.7 хувь байсан бол 2024 онд 71 хувь болж 2 дахин өссөн. Хэрэгжилт 100 хувь
2	4.3.Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд энэхүү гэрээний хавсралтад заасан зорилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв санхүү, хөрөнгө оруулалт, хүний нөөц, удирдлага зохион байгуулалтын ажлыг тусгаж, хэрэгжилтийг хангаж, тайлагнаж ажиллана.	250,0	Гүйцэтгэлийн хувь	100%	Өмнөговь суманд баригдаж буй Спорт заалны барилтын явцад байнгын хяналт хийж, барилтын явцын гүйцэтгэл 70 хувьтай байна. 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Биеийн тамир, спортыг дэмжих” төсөл, хөтөлбөрийг боловсруулж аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Өсвөрийн шигшээ баг байгуулах, санхүүжүүлэх журмыг боловсруулж, Спортын 5 төрөлд өсвөрийн шигшээ баг байгуулах тухай Аймгийн ЗД-ын 2025.10.10-ны өдрийн А/549 тоот захирамж батлагдан гарсан. Журмын дагуу 5 төрөлд 10 дасгалжуулагч ажиллаж байна. БТС-ыг дэмжих төсөл, арга хэмжээний хөтөлбөрийн санхүүжилтэд 250,0 сая төгрөгийг батлуулж, УАШТ зохион байгуулах, үндэсний наадмуудад баг тамирчдыг оролцуулах, тив, дэлхий, олон улсын уралдаан тэмцээнд оролцох баг тамирчдын зардалд дэмжлэг үзүүлэх, урамшуулах, спортын холбоодод арга хэмжээний зардалд дэмжлэг үзүүлэх зэрэг 13 арга хэмжээнд 191,4 сая төгрөгийг зарцуулсан байна. Хэрэгжилт-100%

3	4.7.Нутаг дэвсгэрийн хүн амыг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх, хүртээмжийг сайжруулах хүрээнд хавсралтад заасан арга хэмжээг хэрэгжүүлж биеийн тамир, спортын хөгжлийг хангана.	-	1. Арга хэмжээн ий тоо 2. Оролцогчдын тоо	68138	Иргэдийн биеийн тамираар хичээллэх хөдөлгөөн өрнүүлэх зорилгоор “Алхахад цаг гаргай”, “Ажлын байрны дасгалыг хэвшүүлбэ” аян, “Мөнгөн өвөл” цасны баяр, өсвөр, ахмад, ХБИ-ийн зэрэг нийтийг хамарсан арга хэмжээ, 100 буудалт даамын насанд хүрэгчдийн шилшээ тэмцээн, Кросс гүйлтийн өсвөр болон насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн, байт харваа, жүдо бөхийн баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээн, аймаг, сум, орон нутгийн чанартай спортын уралдаан тэмцээн зэрэг 243 арга хэмжээнд 68250 хүн хамрагдсан байна. Хэрэгжилт: 100 %
4	4.9.Заглуучуудын хувь хүний хөгжил, боловсрол, соёл, урлаг, спорт, шинжтэх ухаан, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, аюулгүй амьдрах, хөгжих орчинд сайжруулж, түүх, соёлоо мэддэг, эх оронч үзэлтэй, бие дааж амьдрах чадвартай, хариуцлагатай иргэнийг нэмэгдүүлэх хүрээнд хавсралтад заасан арга хэмжээг хэрэгжүүлж залуучуудын хөгжил, оролцоог дэмжинэ.	32280, 0	Биеийн тамир, спортоор хичээллэгчдийн тоо	4981	Хүүхэд залуусыг спортоор хичээллэх боломжийг нээх зорилгын хүрээнд Чөлөөт бөхийн У-17, У-23 ангиллын улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, спортын хөгжлийг дэмжих төсөл арга хэмжээний зардалаас 32 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Нийт 43 багийн 850 гаруй тамирчид, багш нар оролцсон. Мөн жүдо бөхийн У-17, У-14, У-12 ангиллын баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнд 5 аймгийн 6 багийн 600 гаруй тамирчид, багш нар оролцсон. 100 буудалт даамын насанд хүрэгчдийн УАШ шилшээ тэмцээн, Кросс гүйлтийн өсвөр, насанд хүрэгчдийн улсын аварга, байт харвааны төрлөөр баруун бүсийн тэмцээнийг зохион байгуулсан нь өсвөр залуу үеийнхэнд спортоор хичээллэх сэдлийг төрүүлэх, тэднээр бахархах, бие бялдраа хөгжүүлэхэд чиглэгдсэн. Өсвөр үе, залуучуудын дунд биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулах, оролцуулахаас гадна спортын арга хэмжээнд сайн дурын ажигтнаар залуучуудыг татан оролцуулсан. 2 удаагийн арга хэмжээнд 50 сайн дурын ажигтанг хамруулсан. Аймгийн хэмжээнд ЕБС, спортын 36 клуб, дэвхээнд нийт спортын 15 спортын төрөлд 4984 тамирчин хичээллэж байна. Хэрэгжилт-100%
					Спортын ордоны их засварын ажлын тооцоог “Өлзий Иш” ХХК-аар гүйцэтгүүлэхээр санал хүргүүлж, төсвийг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна.

5	4.11. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.18 дахь заалтад заасны дагуу салбарын орон нутгийн өмчийн байгууллагын барилта байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварын асуудлыг хариуцаж, тодорхой хөрөнгө зарцуулна.	-			Байгууллагын болон албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах зорилгоор байгууллагын дотно болон гадна талд тохижилт, засвар үйлчилгээ хийх, зүлэг, цэцэг тарих ажлыг зохион байгуулж, сургалтын танхим болон үүдний хэсэгт тохижилт хийгдсэн. Мөн Спортын ордоны шал будах, сургалтын танхим тохижуулах, албан хаагчдын өрөө, ОО-ын өрөөний шал, ханыг шинэчлэн 19,0 сая төгрөгөөр , бөхийн Шандас клубын болон спортын ордоны халаалт, шугам засварын ажлыг албан хаагчдын нөөц боломжоор хийж орон нутгийн төсвөөс 30,0 сая төгрөг, нийт 49 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна. Мөн Сатил, Малчин, Түргэн, Давст сумдад 3х3, 5х5 сагсан бөмбөг, хөл бөмбөгийн талбай, биеийн тамирын талбайг орон нутгийн хөрөнгөөр барьж иргэдийн биеийн тамираар хичээллэх орчинг бүрдүүлсэн. Аймгийн ИТХ-ын 2025 оны 02 дугаар сарын 5-ны өдрийн 25 тоот тогтоолын дагуу байгууллагын үндсэн болон эрэглтийн өмч хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан үндсэн хөрөнгийн 13 төрлийн 41 ширхэг 11,9 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж актлах шийдвэр гарсан. Одоо байгууллагад ашиглахгүй байгаа 52 нэр төрлийн 133 ширхэг 8240,4 төгрөгийн үнэ бүхий бараа материалыг данснаас хасаж актлах тухай өмч хамгаалах зөвлөлийн тогтоолоор шийдвэрлэлээ. Хэрэгжилт 100 хувь
6	4.12.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтын дагуу салбарын орон нутгийн өмчит байгууллагыг шаардлагатай эд хөрөнгөөр хангана.	-			Салбарын хэмжээнд ямар нэгэн худалдан авалт хийгдээгүй байгаа болно. Хандив тусламжийн орлогоор 10,4 сая төгрөгийн ухаалаг самбар, холбогдох хэрэгсэлийн бүртгэн авч байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байна. Хэрэгжилт 100 хувь
7	4.13.Аймгийн соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын асуудал	-	-	-	Төрийн аудитын газраас 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын хяналт шалгалт, Аймгийн санхүү дотоод хяналт, аудитын газраас 2024 оны санхүүгийн баримтад төлөвлөгөөт

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд,
Увс аймгийн Засаг дарга нарын хооронд
байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралт

НИЙТЛЭГ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ
/2025 ОНЫ ЖИЛ ЭЦСЭЭР / УВС АЙМАГ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт
1.1	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын чиглэлээр харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээний стратеги төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх	У ОНТ-191,4 сая төгрөг	Батлагдсан баримт бичиг хэрэгжилтийн хувиар	1	2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Биеийн тамир, спортыг дэмжих” төсөл, хөтөлбөрийг боловсруулж аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх, дэмжих төсөл арга хэмжээнд 250,0 сая төгрөгийг төсөвлөж дараах үйл ажиллагаануудад зарцуулсан. ✓ Тив, дэлхий олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнээс медаль хүртсэн 118 багш, дасгалжуулагч, тамирчдын мөнгөн урамшуулалд 21,5 сая төгрөг ✓ БНХАУ-ын Шинжаан Уйгарын өөртөө засах оронд зохион байгуулагдсан Алтайн уулын салбар, бүс нутгийн өвлийн арга хэмжээнд оролцох 8 тамирчин, 2 дасгалжуулагч, албаны 3 хүний зардалд ,7 5 сая төгрөг ✓ Улаангом хотноо зохион байгуулагдсан Чөлөөт бөхийн У17, У23 насны улсын аварга шалгаруулах тэмцээний тамирчдын шатгалын зардалд 32,2 сая төгрөг ✓ Монголын Хүүхдийн спортын наадмын 8 дугаар наадмын шигшээ тэмцээнд оролцох тамирчид, багш дасгалжуулагчдын унаа, хоолны зардалд 52,0 сая төгрөг ✓ 100 буудалт даамын насанд хүрэгчдийн

					✓ улсын аварга шалгаруулах шигшээ тэмцээний зардалд 15,0 сая төгрөг ✓ Үндэсний их баяр наадмын цол олгох үндэсний бөхийн барилдааны зардалд 3,0 сая төгрөг ✓ Герман улсын Берлин хотод зохион байгуулагдах хөнгөн атлетикийн ДАШТ-д оролцох тамирчин Г.Бат-Эрдэнэд 5,0 сая төгрөг ✓ Баянхонгор аймаг, Улаанбаатар хотноо зохион ба Монголын бүх ард түмний спортын 17 дугаар наадмын шигшээ тэмцээнд оролцох 104 тамирчин, дасгалжуулагчийн зардалд 8 ,36 сая төгрөг ✓ Ховд аймагт зохион байгуулагдах мэдээлэл технологийн баруун бүсийн аварга шалгаруулах Хурдан кап тэмцээнд оролцох тамирчдын зардалд 2,5 сая төгрөг ✓ 100 буудалт даамын өсвөр үеийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчин Б.Сансармаа, Ц.Шинэбаян нарт тус бүр 1,0 сая төгрөг ✓ Улаангом дэвжээний 10 жилийн ойн нэрэмжит өсвөр болон насанд хүрэгчдийн Үндэсний бөхийн баруун бүсийн тэмцээний зардалд 13,8 сая төгрөг ✓ Монголын бүх ард түмний спортын 17 дугаар наадмын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн наадамд оролцох 18 тамирчны зардалд 3,8 сая төгрөг ✓ Улаангом хотноо зохион байгуулагдсан Оюуны бэрхшээлтэй иргэдийн биеийн тамирын арга хэмжээний зардалд 5,0 сая
--	--	--	--	--	--

				төгрөг Нийт 13 арга хэмжээнд 191,4 сая төгрөгийн санхүүжилт, мөнгөн дэмжлэг үзүүлсэн байна.
			10 5 Хэрэгж илтээр	Аймгийн БГ-тай хамтран ЕБС, СӨБ-ийн биеийн тамирын багш нарт 2 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 75 багш, Соёл, спортын ажиглагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам-ын талаарх сургалтад 20 багш дасгалжуулагч хамрагдсан. САУЭШТ, АУА, ЭШССА-ийн эмч мэргэжилтнүүд ЕБС-ийн биеийн тамирын багш, дасгалжуулагчдад “Өсвөр насны хүүхдийн физиологийн онцлог, өсвөрийн тамирчдын бэлтгэл дасгалжуулалт төлөвлөлт, бэлтгэл дасгалжуулалтын төлөвлөгтөд анализ хийх, хэт ачааллын шалтгаан, гэмтлийн дараах яаралтай авах арга хэмжээ, гэмтлийн үед болон урьдчилан сэргийлэх зорилгоор тейп боолт хийх, Спортын хоол зүй, Спортын сэтгэл зүй сургалтад 20 багш, дасгалжуулагч, Оюуны бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиглах арга зүй, тусгай олимпын чиглэлээр эмч мэргэжилтэн, багш, эцэг хамгаалагч, мэргэжилтнүүдэд зориулсан, сургалтад 130 хүн тус тус хамрагдлаа. Нийт 5 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 245 хүнийг хамрууллаа. Байгууллагын албан хаагчдыг ажлын байранд, танхимаар, цахимаар сургалтад хамруулж нийт 26 удаагийн сургалтад 22 албан хаагчийг хамруулсан. Байгууллагын болон албан хаагчдын ажиглах орчин нөхцлийг сайжруулах зорилгоор байгууллагын дотно болон гадна талд тохижилт, засвар үйлчилгээ хийх, зүлэгжүүлэлт, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг зохион байгуулж, сургалтын танхим болон
1.2	Салбарын хүний нөөцийг бэхжүүлэх, мэргэжил дээшлүүлэх, чадавхижуулах сургалт зохион байгуулах, байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмждэг үзүүлэх	Улс болон орон нутгийн төсөв 49,0 сая төгрөг	Бэлтгэсэн мэргэжилтэний тоо, чадавхижуулах сургалтын тоо, нийгмийн баталгаанд дэмжлэг үзүүлсэн дүн	

					УУДНИЙ ХЭСЭЛТ ТОХИЖИЛТ ХИЙГДЛЭЭ. Спортын ордоны шал будах, сургалтын танхим тохижуулах, албан хаагчдын болон ОО-ын өрөөний хаалга, хана шинэчлэх, гадна тохижилт, зүлэгжүүлэлт, цэцэржүүлэлтэд нийт 19,0 сая төгрөг, бөхийн Шандас клубын халаалт, спортын ордоны халаалт, шугам засварын ажилд орон нутгийн төсвөөс 30,0 сая төгрөг нийт 49,0 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна. Хэрэгжилт 100 хувь
1.3	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын байгууллагад ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, зөрчлийн даруу хариуцлага тооцож тайлагнах	Улс болон орон нутгийн төсөв	Хэрэгжилтийн хувиар	100 хувь	БТСГ-ын ёс зүйн дэд хороог 2024 оны 01 сарын 24-ны өдрийн А/07 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 удаагийн сургалтыг аймгийн Прокурорын газартай хамтран Төрийн албан хаагчийн ёс зүй", Төрийн албан хаагч авилгаас ангид байх, авилгын эсрэг хууль тогтоомж" сургалтыг зохион байгуулж байгууллагын 22 албан хаагч хамрагдсан. Ёс зүйн зөвлөлөөс зарласан "Хүндэлбэ-Энэрээ" ёс зүйн нөлөөллийн сарын аянд нэгдэж, аяны хүрээнд байгууллагын албан хаагчид БТСУХороо Удирдлагын академтай хамтран зохион байгуулсан ёс зүйн цуврал лекцид хамрагдаж мэдээлэл авсан. Аймгийн төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Шинэтгэлээр түүчээлсэн төрийн алба" сургалтад 8 албан хаагч оролцсон. -Биеийн тамир спортын Улсын хорооноос цахимаар зохион байгуулсан "Ёс зүйн дэд хорооны ажиглах журам", "ЁЗДХорооны гишүүнийг томилох сургалтад-20 албан хаагч хамрагдсан. -“Ёс зүй гэж юу вэ” сургалтад-21 албан хаагч тус тус хамрагдсан.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд,

Увс аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулсан гэрээний гуравдугаар хавсралт

ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
/2025 ОНЫ ЖИЛ ЭЦСЭЭР / УВС АЙМАГ

[illegible]